



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот


Багахангай дүүргийн баяр наадмын хугацааг
тогтоох, зохион байгуулах хороо, салбар
хорооны бүрэлдэхүүн, дүрмийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус 20 дугаар хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Багахангай дүүргийн баяр наадмыг 2023 оны 07 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсүгэй.
2. Дүүргийн баяр наадмыг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр, салбар хороодын бүрэлдэхүүнийг хоёрдугаар, наадам зохион байгуулах хороо, үндэсний бөх, сурын харваа, хурдан морь, шагайн харвааны дүрмийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Баяр наадмын бэлтгэлийг сайтар ханган батлагдсан дүрмийн хэрэгжилтийг ханггуулж өндөр түвшинд зохион байгуулж ажиллахыг дүүргийн Засаг дарга (А.Сүхболд)-д даалгасугай.

ДАРГА

Ф.МӨНХГЭРЭЛ



1029000 241

Нийслэлийн Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын ~~2023~~ оны ~~06~~ сарын ~~26~~...ны өдрийн
~~1/20~~ дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Хорооны дарга:	Б.Болормаа	Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч
Нарийн бичгийн дарга: Гишүүд:	Л.Санжийжамц М.Давааням	Засаг даргын Тамгын газрын дарга Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга
	Б.Отгонжаргал	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Ц.Мягмарсүрэн Б.Цогжавхлан Д.Хүрэлбаатар	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
	Ш.Бат-Өлзий Н.Нямзав	Цэргийн штабын дарга 1 дүгээр хорооны Засаг дарга
	Б.Батзориг О.Содовжамц	2 дугаар хорооны Засаг дарга Худалдан авах ажиллагааны албаны дарга
	Ш.Баасансүрэн Д.Оюунгэрэл	Боловсролын хэлтсийн дарга Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн дарга
	Б.Цогбадрах	Онцгой байдлын хэлтсийн дарга, Онцгой байдлын хурандаа
	Т.Лхагвасүрэн	Цагдаагийн хэлтсийн дарга, Цагдаагийн хурандаа
	Х.Ганбат Ц.Жамбалцэрэн	Эрүүл мэндийн төвийн дарга Багахангай Үйлдвэрлэл, технологийн парк ОНӨААТҮГ-ын захирал
	Б.Гэрэлмаа	“Багахангай тохижилт” ОНӨААТҮГ-ын захирал
	Д.Гантулга Ч.Батхуяг	Илч-Орд ОНӨААТҮГ-ын захирал “Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ-ын захирал
	С.Алтанхүү	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨК-ний Ашиглалт Засварын Налайх Төвийн Багахангай хэсгийн мастер
	Я.Батсүх	Мал эмнэлгийн тасгийн дарга

Нийслэлийн Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2023 оны 06 сарын 26.-ны өдрийн
1/20 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

САЛБАР ХОРООДЫН БҮРЭЛДЭХҮҮН

Ёслол хүндэтгэл, мэдээлэл сурталчилгааны салбар хороо

Дарга:	Б.Отгонжаргал	Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга 1 дүгээр хорооны Засаг дарга
Гишүүд:	Н.Нямзав Б.Батзориг П.Дэлгэр Б.Гэрэлцолモン Б.Отгонжаргал Б.Намуунтуяа Н.Батболд Г.Батмөнх С.Баасанхүү	2 дугаар хорооны Засаг дарга Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасгийн эрхлэгч, нярав Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын тоо бүртгэл, нөхөн хангалтын офицер Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Ажлын албаны мэргэжилтэн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэн Засаг даргын Тамгын газрын Мэдээ мэдээлэл хариуцсан ажилтан Засаг даргын Тамгын газрын Еренхий нягтлан бодогч

Үндэсний бөхийн салбар хороо

Дарга:	М.Баянцогт	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч
Гишүүд:	Г.Тэмүүлэн Ш.Баасансүрэн Э.Соёмбобат Х.Ганбат Н.Батсайхан А.Ойбаяр	Биеийн тамир, спорт хорооны дарга Боловсролын хэлтсийн дарга Хангай цогцолбор сургуулийн захирал Эрүүл мэндийн төвийн дарга Ус суваг ашиглалтын товчооны дарга Бөх хурах дэвжээ

Морины салбар хороо

Дарга:	Г.Дагвадорж	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч
Гишүүд:	Б.Цогбадрах Д.Оюунгэрэл Д.Билгээ	Онцгой байдлын хэлтсийн дарга, хурандаа Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн дарга Багахангай дүүрэг дэх Цагдаагийн

		Хэлтсийн Замын цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн дэд хурандаа
	Ш.Бат-Өлзий	Засаг даргын Тамгын газрын Цэргийн Шабын дарга
	Я.Батсүх	Мал эмнэлгийн тасгийн дарга
	А.Цэрэндагва	Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн захирал
	Г.Одонбаатар	Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
	О.Номиндалай	Эрүүл мэндийн төвийн эмч
Шагайн харвааны салбар хороо		
Дарга:	Ц.Жамбалцэрэн	Багахангайн Үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын захирал
Гишүүд:	Д.Энхтайван	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга
	Б.Хүрэл-Эрдэнэ	Шагайн харвааны аймгийн гоц мэргэн
	Л.Мөнхбаяр	Шагайн харвааны аймгийн гоц мэргэн
	Б.Ганбаяр	Биеийн тамир, спортын хорооны Спорт хариуцсан мэргэжилтэн
Сур харвааны салбар хороо		
Дарга:	О.Содовжамц	Худалдан авах ажиллагааны албаны дарга
Гишүүд:	Э.Эрдэнэтүяа Ч.Магадсайхан	Дотоод Аудитын албаны дарга Газар зохион байгуулалтын албаны дарга
	А.Анхбаяр	Татварын хэлтсийн дарга
	Д.Гантулга	Илч-Орд ОНӨААТҮГ-ын захирал
Төсөв санхүү, хандив хариуцсан салбар хороо		
Дарга:	Ц.Мягмарсүрэн	Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Гишүүд:	Э.Сувд-Эрдэнэ А.Алтантуяа	Засаг даргын Тамгын газрын тооцооны нягтлан бодогч Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Ё.Гэрэлцэцэг	Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн
	С.Бүрэнтөгс Г.Буянхишиг	Татварын хэлтсийн мэргэжилтэн Татварын хэлтсийн мэргэжилтэн
Хэв журам сахиулах салбар хороо		
Дарга:	Т.Лхагвасүрэн	Цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа
Гишүүд:	Б.Цогбадрах	Онцгой байдлын хэлтсийн дарга, хурандаа

Б.Батбаяр

824-р тусгай салбарын захирагч

Соёл урлагийн салбар хороо
Дарга: Б.Цогжавхлан
Гишүүд: Н.Нямзав
Б.Батзориг
Б.Алтанцожж
Б.Нямгарав

Ч.Батхуяг

Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
1 дүгээр хорооны Засаг дарга
2 дугаар хорооны Засаг дарга
Соёлын ордны захирагч
Нийгмийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн
“Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ-ын захирагч

Тохижилт үйлчилгээний салбар хороо
Дарга: Д.Хүрэлбаатар

Гишүүд: Б.Гэрэлмаа
Д.Гантулга
Ч.Батхуяг

Ё.Гэрэлцэцэг

Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
“Багахангай тохижилт” ОНӨААТҮГ-ын захирагч
Илч-Орд ОНӨААТҮГ-ын захирагч
“Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ-ын захирагч
Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн

Нийслэлийн Багахантай дуургийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2023 оны 06 сарын 26-ны өдрийн
01/20 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт

ДҮҮРГИЙН БАЯР НААДМЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ дүрмээр дүүргийн баяр наадмыг хууль тогтоомж, уламжлалт ёс заншил, өв соёл, орчин үеийн технологид тулгуурлан тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах, дүүргийн баяр наадмыг зохион байгуулах хорооны үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Дүүргийн баяр наадмыг зохион байгуулах хороо (цаашид "Хороо" гэх) нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний их баяр наадмын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Биеийн тамир спортын тухай хууль бусад хууль тогтоомж, дүрэм журам, холбогдох стандартыг мөрдөж ажиллана.

Хоёр. Хорооны удирдлага, зохион байгуулалт

2.1. Хороо нь орон тооны бус байх бөгөөд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.2. Хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд хуралдаанд нийт гишүүдийн олонх оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцно.

2.3. Хорооны дарга нь хуралдааны дэгийг тогтоож, хуралдааныг удирдах бөгөөд түүний эзгүйд нарийн бичгийн дарга бүрэн эрхийг нь хэрэгжүүлнэ.

2.4. Хуралдааны явцын тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлж, хорооны дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

2.5. Хороо нь Салбар хороог аль нэг гишүүнээр ахлуулан байгуулж ажиллуулах бөгөөд дараах салбар хороотой байна:

2.5.1. Үндэсний бөхийн салбар хороо;

2.5.2. Хурдан морины салбар хороо;

2.5.3. Сурын харвааны салбар хороо;

2.5.4. Шагайн харвааны салбар хороо;

2.5.5. Соёл урлагийн салбар хороо;

2.5.6. Ёслол, хүндэтгэл, мэдээлэл сурталчилгааны салбар хороо;

2.5.7. Хэв журам сахиулах салбар хороо;

2.5.8.Тохижилт, үйлчилгээний салбар хороо;

2.5.9.Төсөв, санхүү, хандив хариуцсан салбар хороо.

2.6. Салбар хороо нь Хорооноос өгсөн үүрэг, даалгавар, батлагдсан төлөвлөгөө, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

Гурав.Хорооны бүрэн эрх

3.1.Хороо нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

3.1.1.Дүүргийн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг хариуцан баяр наадмын нээлт, хаалт, үндэсний бөхийн барилдаан, үндэсний хурдан морины уралдаан, үндэсний сурын болон шагайн харваа, ёслол, хүндэтгэл, соёл урлаг, худалдаа үйлчилгээ, хэв журам сахиулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын дагуу зохион байгуулах;

3.1.2.Үндэсний их баяр наадмын тухай хуулийг хэрэгжүүлэх талаар Дүүргийн Засаг даргаас гарах шийдвэрийн төсөл боловсруулах;

3.1.3.Хорооны болон салбар хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө, үйл ажиллагааг нь удирдан чиглүүлж, хяналт тавин, тайланг хэлэлцэх;

3.1.4.Дүүргийн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах төсвийн төслийг хуульд заасан хугацаанд боловсруулан батлуулж, зориулалтын дагуу зарцуулах, төсвийг салбар хороодод хуваарилж, зарцуулалтад нь хяналт тавих;

3.1.5.Салбар хорооноос баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх талаар зохион байгуулсан ажил, санхүүгийн тайланг баяр наадам дууссанаас хойш ажлын 7 өдөрт багтаан авч нэгтгэн үнэлэлт, дүгнэлт өгөх;

3.1.6.Дүүргийн баяр наадамд оролцож байгаа бөх, уяач, харваач, уралдаанч хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон холбогдох бусад этгээдээс гаргасан гомдол, саналыг өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх;

3.2.Хороо нь дараах асуудлаар холбогдох төрийн байгууллагад санал гаргах эрхтэй:

3.2.1.Дүүргийн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх хөтөлбөрийн төсөл боловсруулж, санал авах;

3.2.2.Салбар хороодын төсөвт өөрчлөлт оруулах;

3.2.3.Дүүргийн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд идэвх зүтгэл, санаачилгатай ажилласан хүмүүст мөнгөн шагнал олгох, бусад хэлбэрээр урамшуулах, төр, засгийн шагналаар шагнуулах тухай саналаа холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;

3.2.4.Хороо болон салбар хорооноос өгсөн үүрэг даалгаврыг хангалтгүй биелүүлсэн гишүүн, албан тушаалтанд хариуцлага тооцуулах талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд санал хүргүүлэх.

Дөрөв.Хариуцлага

4.1.Хороо нь ёс зүй, сахилга хариуцлагын дүрмийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

ДҮҮРГИЙН БАЯР НААДМЫН БӨХИЙН БАРИЛДААНЫ ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Дүүргийн баяр наадмын үндэсний бөхийн барилдаантай холбоотой харилцааг зохицуулахад энэхүү дүрмийг мөрдөнө.

1.2.Үндэсний их баяр наадмын тухай хууль болон холбогдох дүрэм журмыг мөрдөж ажиллана.

Хоёр.Үндэсний бөхийн барилдааны салбар хороо

2.1.Дүүргийн наадмын үндэсний бөхийн барилдааныг үндэсний бөхийн барилдааны салбар хороо (цаашид “салбар хороо” гэх) хариуцан зохион байгуулна.

2.2.Салбар хорооны бүрэлдэхүүнийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батална.

2.3.Салбар хороо бөхийн барилдаантай холбоотой гарсан санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, хариу өгөх, тайлан тооцоо гаргах ажлыг хариуцна.

Гурав.Бөхийг бүртгэх, эрэмбэлэх

3.1. Баяр наадмын бөхийн барилдааны бүртгэлийг барилдаан эхлэхээс 2 хоногийн өмнө тогтоосон цагт эхлүүлж, барилдаан эхлэхээс 1 хоногийн өмнө дуусгана. Бүртгэлд 128 бөхийн тоо гүйцвэл дээрх хугацааг харгалзахгүй бүртгэл хаана.

3.2. Үндэсний бөхийн барилдааны 3-ын даваанаас эхлэн бөхчүүд цол, амжилтын эрэмбээр ам авч барилдана.

3.3.Өсвөрийн үндэсний бөхийн барилдааныг зохион байгуулж болно. Барилдааны зохион байгуулалтыг салбар хороо хариуцна.

Дөрөв.Ерөнхий шаардлага

4.1.Бөхчүүд бүртгүүлэхдээ иргэний үнэмлэх, цолтой бөхчүүд цолны үнэмлэх (1 хувь цээж зураг, ослын даатгалын хуудас, бүртгэлийн хураамж 20,000 төгрөг) авчран өөрийн биеэр ирж бүртгүүлнэ.

4.2.Барилдах бөхчүүд Монголын Үндэсний бөхийн холбооны шинэчилсэн дүрмийн дагуу стандартад нийцсэн зодог, шуудагтай барилдана. Дүрмийн бус өмсгөлтэй бөхийг барилдаанаас хасах хүртэлх арга хэмжээг авна.

4.3.Бүртгүүлсэн бөх нэр дуудсанаас хойш гарч ирэхгүй 10 минут хоцорвол тухайн бөхийг хасаж ам буюу угтуул бөхийг давуулна.

4.4.Бөхийн барилдааныг Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдааны дүрмийн дагуу зохион байгуулна.

Тав.Цол, чимэг, шагнал урамшуулал олгох

5.1.Дүүргийн баяр наадамд 5 давсан бөхөд аймгийн начин цол, үзүүрлэсэн бөхөд Аймгийн заан цол, түрүүлсэн бөхөд Аймгийн арслан цолыг Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт заасны дагуу олгоно.

5.2.Давааны мөнгө болон шөвгөрсөн бөхчүүдийн бай шагналыг зохион байгуулах хорооны шийдвэрээр салбар хороо олгоно.

Зургаа.Хариуцлага, хориглох зүйл

6.1.Барилдааны дундуур бөх ёс зүйн зөрчил, дүрмийн бус үйлдэл гаргавал барилдаанаас хасах хүртэл арга хэмжээ авч, давааны бай шагнал олгохгүй.

6.2.Улс, аймгийн цолтой бөх 1-ийн даваанд барилдаагүй буюу хоцорч ирсэн тохиолдолд 2-ын даваанаас оруулж барилдуулахыг хориглоно.

Долоо.Бусад

7.1.Бүртгүүлсэн бөхчүүд нээлтийн үйл ажиллагаанд оролцож жагсах эсэхийг наадмыг зохион байгуулах хорооны шийдвэрээр зохицуулна.

7.2.Салбар хороо нь бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу хуваарьт ажлаа 07 дугаар сарын 10-ыг хүртэлх хугацаанд ханган биелүүлсэн байна.

ДҮҮРГИЙН БАЯР НААДМЫН СУРЫН ХАРВААНЫ ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Дүүргийн баяр наадмын сурын харваа (цаашид "Дүүргийн сурын харваа" гэх)-г зохион байгуулахад Үндэсний их баяр наадмын тухай хууль болон энэхүү дүрмийг мөрдөнө.

1.2.Үндэсний сурын харвааны хэрэгсэл, харвааны бай болон зайд, харваач, шүүгчдийн эрх, үүргийг Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулна.

Хоёр.Сурын харвааны салбар хороо

2.1.Дүүргийн баяр наадмын сурын харвааг сурын харвааны салбар хороо (цаашид "салбар хороо" гэх) хариуцан зохион байгуулна.

2.2.Салбар хорооны бүрэлдэхүүнийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батална.

2.3.Салбар хороо сурын харваатай холбоотой гарсан санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, хариу өгөх, тайлан тооцоо гаргах ажлыг хариуцна.

Гурав.Тэмцээний хугацаа

3.1.Дүүргийн сурын харвааны тэмцээнийг 2023 оны 07 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулна.

3.2.Тэмцээний бүртгэлийг салбар хорооноос тогтоосон хугацаанд заасан газарт бүртгэнэ.

3.3.Бүртгэлд хамрагдаагүй харваачийг тэмцээнд оруулахгүй.

Дөрөв.Харваанд оролцох нөхцөл

4.1.Сурын харваа нь Монголын үндэсний сурын харвааны дүрмийн дагуу явагдана.

4.2.Үндэсний сурын харвааг эрэгтэй, эмэгтэй гэсэн ангиллаар зохион байгуулна.

4.3. Өсвөрийн харвааны тэмцээнийг зохион байгуулж болно. Тэмцээний зохион байгуулалтыг салбар хороо хариуцна.

4.4.Харваачид нь салбар хорооноос зарласан хугацаанд иргэний үнэмлэхтэй, өөрийн биеэр ирж бүртгүүлэх бөгөөд цолтой харваачид цолны үнэмлэхтэй байна.

Тав.Харвааны зохион байгуулалт

5.1.Тэмцээнийг салбар хорооноос томилсон шүүгчдийн бүрэлдэхүүн удирдан явуулна.

5.2.Самбарын шүүгч, зурхайн шүүгч нарыг самбар босгосны дараа сугалаагаар оноож зурхай хуваарилан ажиллуулна.

5.3.Тэмцээний явцад сум хугарвал сум буцаахгүй харваач нөөц сумаар харвана.

5.4.Харваачдыг хана болон хасаа суранд оносон онооны нийлбэрээр цуваагаар байр эзлүүлэх бөгөөд ижил оноотой тохиолдолд харваачдыг товх харвуулж шалгаруулна.

5.5.Маргаан гарвал ерөнхий шүүгч шийдвэрлэх ба харвах босоондоо самбарын шүүгчдээ мэдэгдээгүй хүндэтгэх шалтгаангүй хоцорсон харваачийн сумыг нөхөж харвуулахгүй оноогүйд тооцно.

Зургаа.Бай шагнал

6.1.Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т заасны дагуу харваачдад цол олгоно.

6.2.Тэмцээнд нийлбэр дүнгээр эрэгтэй, эмэгтэй эхний таван байрыг шалгаруулж, медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

Долоо.Хариуцлага, хориглох

7.1.Нумны бариул, нуман дээр нэмэлт хэрэгсэл хийж хэлбэр загвар өөрчлөхийг хориглоно.

7.2.Үндэсний сурынхаас өөр төрлийн харвааны хэрэгслээр харваанд оролцохыг хориглоно.

7.3.Эрхийвчлэхээс өөр арга барилаар харваа үйлдэхийг хориглоно.

7.4.Энэхүү дүрмийг зөрчсөн салбар хорооны гишүүд, шүүгч, харваачдад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

7.5.Согтууруулах ундаа хэрэглэсэн, бүртгэлд хамрагдаагүй харваачийг тэмцээнд оролцохыг хатуу хориглоно.

**ДҮҮРГИЙН БАЯР НААДМЫН
ХУРДАН МОРИНЫ УРАЛДААНЫ ДҮРЭМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Дүүргийн баяр наадмын хурдан морины уралдаан (цаашид "хурдан морины уралдаан" гэх)-ыг зохион байгуулахад Үндэсний их баяр наадмын тухай хууль болон энэхүү дүрмийг мөрдөнө.

Хоёр.Хурдан морины уралдааны салбар хороо

2.1.Хурдан морины уралдааныг Хурдан морины уралдааны салбар хороо (цаашид "Салбар хороо" гэх) хариуцан зохион байгуулна.

2.2.Салбар хорооны бүрэлдэхүүнийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас батална.

2.3.Салбар хороо хурдан морины уралдааныг хариуцсан даамал, шүдлэгч, морь бариач, цоллогч, хүний эмч, хүүхдийн эрхийн ажилтан, малын эмч бүхий шүүгчдийн багийг томилно. Тухайн насанд уралдах морь, морь унах хүүхэд (цаашид "уралдаанч хүүхэд" гэх)-ийг бүртгэх, дугаар олгох, уралдаанд гаргахыг шүүгчидтэй хамтран Салбар хороо зохион байгуулна. Хурдан морины уралдааны даамал нь гарaa, бариаг зохион байгуулах, түрүүлсэн, айрагдсан морьдыг цоллуулах, уяач, уралдаанч хүүхэд, морины бай шагналыг олгох, уралдаантай холбоотой гарсан санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, хариу өгөх, тайлан тооцоо гаргах ажлыг хариуцна.

2.4.Салбар хорооны авто машин өөрийн таних тэмдэг, дарцагтай байна.

2.5.Салбар хороо нь уралдааныг зохион байгуулахаас өмнө дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.5.1.Баяр наадам эхлэхээс 10 хоногийн өмнө морины бэлчээр, худаг ус, морь шүдлэх цэг, уралдах замыг (замын дагуух бартаа, гуу жалга гэх мэт) үзэж засан сайжруулах, цэвэрлэх болон холбогдох бусад арга хэмжээг авах, морь барыаны газар хэрэглэх эрчим хүч, холбооны эх үүсвэрийг зохицуулах, хорооны гишүүд, шүүгчдийн ажиллах нөхцөлийг хангах;

2.5.2.Хурдан морины гарааны зурхайг нас бүрийн ангиллаар тогтоох;

2.5.3.Уралдаанч хүүхдийг ослын даатгалд хамруулсан байдал, тусгай зориулалтын хамгаалалтын малгай, цээжиковч, өвдөг, тохойны хамгаалалт, хүүхдийн гуталд таарсан хамгаалалт бүхий дөрөөтэй эмээл зэргээр хангасан эсэхийг хянаж, уралдааны аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах;

2.5.4.Уяачид, уралдаанч хүүхдэд морин уралдааны холбоодын санал, спортын цол зэргийн нэгдсэн ангиллыг үндэслэн цол олгуулахаар Зохион байгуулах хороо, дүүргийн Засаг даргад мэдүүлэх;

Гурав.Уяачид, уралдаанч хүүхдэд тавих шаардлага

3.1.Уяач, уралдаанч хүүхэд нь Үндэсний их баяр наадмын тухай хууль болон энэ дүрэмд заасан эрхийг эдэлж, доорх үүргийг ёсчлон биелүүлнэ.

3.1.1.Үндэсний морин уралдааны морь уралдаанч хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага MNS 6264 : 2018 стандартыг мөрдөх;

3.1.2.Уралдах морийг 8 болон түүнээс дээш настай, морь унаж, давхиулж сурсан, эрүүл хүүхдээр унуулах;

3.1.3.Хурдан морины эзэн, уяач нар уралдаанч хүүхдийг ослын даатгалд даатгуулж, эрүүл мэндийн үзлэгт заавал хамруулсан байх;

3.1.4.Хурдан морины эмээл, энэ дүрмийн 2.5.3-т заасан хамгаалах хэрэгслийг тухайн морь, хүүхдийн биед тохируулж, аюулгүй байдлыг хангасан байх;

3.1.5.Уралдаанч хүүхдэд морины зурхайд хүрч, зөвхөн даамлын дохиогоор морио эргүүлэх, уралдааны замыг товчлохгүй, гүйцэж ирсэн моринд саад учруулахгүй байх талаар заавар, зөвлөгөө өгч ойлгуулсан байх;

3.1.6.Уралдааны үед морины эзэн, уяач, уралдаанч хүүхэд холбооны техник хэрэгсэл ашиглан уралдааныг удирдахгүй байх;

3.1.7.Уралдаанч хүүхэд тухайн морийг унаж уралдахаас татгалзвал уяач, эцэг, эх, асран хамгаалагч нь албадахгүй байх;

3.1.8.Эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийн хуудсыг бөглүүлсэн байх;

3.1.9.Уяач нь уралдаанч хүүхдийн төрсний гэрчилгээ болон эрүүл мэндийн даатгалын гэрчилгээг бүрдүүлсэн байх;

3.1.10.Уяач нь уралдааны үед мориноос унаж бэртэж гэмтсэн уралдаанч хүүхдийн талаар эрүүл мэндийн болон хүүхдийн эрхийг хамгаалах байгууллага, хүүхдийг эрхийн улсын байцаагчид заавал мэдэгдсэн байх.

Дөрөв.Хурдан морь уралдуулах нас, зайл тогтоох

4.1.Хурдан морины уралдааны уралдах нас, зайл дүүргийн баяр наадам зохион байгуулах хороо Үндэсний их баяр наадмын тухай хууль болон холбогдох дүрэм журамд нийцүүлэн тогтооно.

4.2.Салбар хороо нь спортын холбоодын саналыг үндэслэн тухайн жилийн цаг агаарын байдал, малын онд оролт, тарга хүч, уралдах газрын онцлог зэрэгтэй уялдуулан уралдааны зайл өөрчлөн тогтоож болно. Хурдан морины уралдааны зайл шинэчлэн тогтоосон тухайгаа уралдаан зохион байгуулахаас 20-иос доошгүй хоногийн өмнө нийтэд зарлаж мэдэгдсэн байна.

Тав.Уралдах морьдыг бүртгэх, дугаар олгох

5.1.Хурдан морины уралдаанд энэ дүрмийн шаардлагыг хангасан уралдаанч хүүхэд, уяачдыг оролцуулна.

5.2. Салбар хорооноос зарласан хугацаа, заасан газарт дараах баримт бичгийг үндэслэн уралдаанч хүүхэд, уралдах морийг бүртгэж, дугаар олгоно. Үүнд:

5.2.1. Уралдаанч хүүхдийн төрсний гэрчилгээ болон эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ;

5.2.2. Хурдан морь унахыг зөвшөөрсөн эцэг, эх, асралтад хамгаалагчийн зөвшөөрлийн хуудас;

5.2.3. Уралдаанч хүүхдийн ослын даатгалын баталгаа;

5.2.4. Бүртгэлийн хураамж 10,000 төгрөг

5.3. Бичиг баримтыг бүрдүүлээгүй буюу уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг бүрэн хангагүй тохиолдолд уралдаанд оролцуулахгүй хасна.

5.4. Уяач салбар хорооноос олгосон дугаарыг уралдаанч хүүхдийн биед хойд, урд талаас нь харагдахуйц бэхэлсэн байна.

5.5. Бүртгэх цагаас хоцорсон уралдаанч хүүхэд, уралдах морийг бүртгэхгүй.

Зургаа. Уралдааны гарааны үеийн зохион байгуулалт

6.1. Уяачид уралдах морьдоо морь уралдах газар авчирч цуглармагц төрийн далбааг мандуулсан манлайлагч бүх морьдыг дагуулан, индрийг нар зөв гурав тойроод нэгдсэн журмаар гарна.

6.2. Их наснаас бусад насны морийг бэлтгэсэн талбайд шүдэлж сэrvээний өндрийг хэмжинэ. Тухайн насны уралдаанд шүдэлгээ болон сэrvээний өндөр тохигоогүй морийг тусгай хашаанд оруулж, уралдаанч хүүхдэд олгосон дугаарыг хураан авч уралдаанд оролцуулахгүй.

6.3. Морьдыг гарааны зурхайд хүргэж эргүүлэхийг Салбар хорооны дарга, гишүүд, морины даамал, тусгайлан бэлтгэсэн хүмүүс, эмнэлгийн түргэн тусlamжийн ажилтнууд хамтран гүйцэтгэнэ.

6.4. Морьдыг гарааны зурхайгаас даамлын дохиогоор эргүүлнэ.

6.5. Гарааны зурхайд хүрээгүй байхад морь эргүүлэх, замаас морь оруулахыг хориглоно. Зурхайд хүрч, даамлын дохиогоор эргээгүй болон замаас оруулсан морьдыг барихгүй.

Долоо. Уралдааны үеийн зохион байгуулалт

7.1. Уралдааны үед тухайн насны морьдын уралдааныг хариуцсан даамал төрийн далбааг мандуулан, эхний мориноос 100 метрээс холгүй зайд өмнө нь явж замчилна.

7.2. Хүн, мал эмнэлгийн тусlamжийн хэсэг морьдын ард явж мориноос хүүхэд унасан тохиолдолд шаардлагатай тусlamж үйлчилгээг яаралтай үзүүлнэ.

7.3.Уралдааны үед уралдаанч хүүхэд унаж бэртэх, уралдааны замаас морь гарах, гаднаас морь орж ирэх зэрэг болзошгүй үйлдлийг хянах ажлын хэсгийг уралдах морьдын нас бүрд томилно.

7.4.Уралдах морийг зурхайд урьдчилан аваачих, замаас оруулах, хөөх, саад хийх, уралдаж байгаа морьдыг тосон цулбуурдаж хөтлөхийг хориглоно. Ийм тохиолдол гарсан үед дүрс бичлэг, баримт нотолгоо зэргийг үндэслэн тухайн морьдыг уралдаанаас хасна.

7.5.Салбар хороо нь энэхүү дүрмийн 7.1, 7.2, 7.6-д заасан нөхцөлөөр тээврийн хэрэгсэлд морины уралдаан дагах таних тэмдэг бүхий зөвшөөрөл олгох бөгөөд Салбар хорооны зөвшөөрөлгүй тээврийн хэрэгслээр морины уралдаан дагахыг хориглоно.

7.6.Хэвлэл мэдээллийн ажилтнууд Салбар хорооны зөвшөөрөлтэй уралдаанд саад болохгүйгээр морьдыг дагаж нэвтрүүлэг, бичлэг хийж болно.

Найм.Барианы үеийн зохион байгуулалт

8.1.Барианы зурхайг цагаан шугамаар тэмдэглэсэн байна.

8.2.Уралдаж ирсэн эхний таван морийг морь бариачид барих бөгөөд бусад морьдыг барианы зурхайд ирсэн дараалал, хүүхдийн дугаараар нь дүрс, дуу бичлэгийн техник хэрэгсэл ашиглан байр эзлүүлнэ.

8.3.Барианд орсон морьдыг хоёроос доошгүй дуудагчийн цуваа болон зурхайн баруун, зүүн талаас бичсэн дүрс бичлэгийн дүнг харьцуулан байр эзлүүлэн бүртгэнэ. Маргаантай асуудлыг даамал нь Салбар хороо болон шүүгчдийн хамтарсан хуралд оруулж шийдвэрлүүлнэ.

8.4.Хүүхэдгүй уралдаж ирсэн морийг таван байраар ухраан барина. Жолоог нь дэл, сойлго, эмээлд нь уяж бэхлэх зэрэг зориуд зохион байгуулж, хүүхэдгүй уралдуулсан морийг хасна.

8.5.Морьд барианд зэрэгцэн орсон бол барианы зурхайд түрүүлж хошуу нь давсан морийг, морьдын хошуу зэрэгцсэн тохиолдолд зөв талын морийг түрүүлж барих бөгөөд үүнийг дуудагчийн цуваа болон дүрс бичлэгийн техник хэрэгслийг ашиглан тогтооно.

Ес.Морь цоллох, бай шагнал олгох журам

9.1.Баяр наадамд түрүүлсэн, айрагдсан морьдыг эзэн, уясан уяач, уралдаанч хүүхдийн нэрээр цоллон алдаршуулж, бай шагналыг наадамчдын өмнө олгоно. Нас тус бүрд уралдсан морьдын эхний 15 хүртэл барьж, бай шагналыг 07 дугаар сарын 11-ний өдөр наадмын талбайд олгоно.

9.2.Түрүүлсэн, айрагдсан хурдан моринд олгох бай шагналын 20-иос доошгүй хувь нь уралдаанч хүүхдэд ногдоно.

Арав.Бусад зүйл

10.1.Хурдан морины уралдаантай холбогдон гарсан маргааныг салбар хороо шийдвэрлэнэ.

10.2. Салбар хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл Зохион байгуулах хороонд, Зохион байгуулах хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд тус тус гомдол гаргаж болно.

ДҮҮРГИЙН БАЯР НААДМЫН ШАГАЙН ХАРВААНЫ ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Дүүргийн баяр наадмын шагайн харваатай холбоотой харилцааг зохицуулахад энэхүү дүрмийг мөрдөнө. Энэхүү дүрэмд шагайн харвааны төрөл, зохион байгуулалтыг тусгасан болно.

Хоёр. Салбар хороо

2.1. Шагайн харваа тэмцээнийг Шагайн харвааны салбар хороо (цаашид "Салбар хороо" гэх) хариуцан зохион байгуулна.

2.2. Салбар хорооны бүрэлдэхүүнийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас батална.

2.3. Салбар хороо шагайн харваатай холбоотой гарсан санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, хариу өгөх, тайлан тооцоо гаргах ажлыг хариуцна.

Гурав. Шагайн харвааны төрөл

3.1. Баяр наадмын шагайн харвааг багийн, цуваа харваа гэсэн 2 ангилаар "Шагайн харвааны тэмцээний дүрэм"-ийн дагуу явуулна.

Дөрөв. Шагайн харвааны зохион байгуулалт

4.1. Тэмцээнийг дүүргийн баяр наадмын шагайн асарт 2023 оны 07 дугаар сарын 11-ний өглөө 08:00 цагт эхлүүлж өдөртөө багтаан дуусгана.

4.2. Харваачдын сум тавих ээлжийг үе (баг тус бүрээс хоёр, хоёр харваач салаавчилж сууж харвана) гэнэ. Эхний үеийг "нийлэг үе", дараагийн үеийг "шувтарга үе", сүүлчийн үеийг "мэргэ үе" гэж нэрлэнэ. Баг үеэ өөрсдөө зохион байгуулна.

4.3. Шагайн харвааны багийн төрөлд 8 харваач байна. Багийн хураамж 40,000 төгрөг байна.

4.4. Өсвөрийн шагайн харвааны тэмцээнийг зохион байгуулж болно. Тэмцээний зохион байгуулалтыг салбар хороо хариуцна.

4.5. Шагайн харвааг Үндэсний их баяр наадмын тухай хууль болон Монголын шагайн харвааны холбооны дүрмийн дагуу салбар хороо зохион байгуулна.

Тав. Хориглох зүйл

5.1. Нэг багийн харваачид тухайн багтай тэмцээн эхэлснээс хойш тоглож дуустал хугацаанд уухайлахаас өөрөөр нэг нь нөгөөгөө удирдах барил, харвааг заах;

5.2. Нөгөө багийн харваачдыг суудлаар шахах, амжилтыг бууруулахад чиглэсэн ямар нэг сөрөг үйлдэл (бархирах, орилох, хашхирах г.м) хийх. Хэрэв эсрэг багийн харваачийг алдуулах зорилготой дээрх үйлдэл илэрвэл сум тавих гэж байгаа харваачийг сумыг нь тавиулалгүй оносонд тооцно.

5.3. Нөгөө багийн харваачийн сумыг өөрт нь шидэж өгөх;

5.4. Тэмцээнд оролцож буй харваачид, хасаа маллагчдыг байц суудал дээр ярих, ус, ундаа уухыг хориглоно.

Зургаа.Шагайн харвааны тэмцээн

6.1. Тэмцээнд оролцогч багуудыг бүсчлэх буюу тойрч тоглуулах, бөхчлөх \нугалах\ журмаар тэмцээнийг зохион явуулна. Тэмцээнийг бүсчлэх, тойрох, бөхчлөх \нугалах\ асуудлыг оролцогч багийн тоо, цаг хугацааны байдал зэргийг харгалзан багийн ахлагчдын техникийн зөвлөгөөнөөр шийднэ.

6.2. Багуудын тоглох дарааллыг зөвхөн сугалаагаар хийнэ.

Долоо.Шүүгчийн бүрэлдэхүүн, эрх үүрэг

7.1. Салбар хороо шүүгчийн бүрэлдэхүүн (коллеги)-ийг томилно. Шүүгчийн бүрэлдэхүүнд Ерөнхий шүүгч, Нарийн бичгийн дарга, шүүгчид, туршлагатай ахмад харваачид, шагай харвах дүрмийг сайн мэддэг хүмүүсийг оролцуулна.

7.2. Тэмцээний дүнг нэгтгэж бай шагналыг олгох, тэмцээнтэй холбоотой гарсан санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, хариу өгөх, тайлан тооцоо гаргах ажлыг хариуцна.

7.3. Тоглолтын явцыг байнга хянаж, тоглолтын явцад санал зөрөх, гомдол гарвал газар дээр нь шийдвэрлэх.

Найм.Хариуцлага

8.1. Шагайн харваатай холбогдон гарсан маргааныг салбар хороо шийдвэрлэнэ.

8.2. Салбар хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл зохион байгуулах хороо, хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд тус тус гомдол гаргаж болно.